МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**САНГИЙН ЯАМ**

*Хавсралт 1*

# ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2022-2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ БЭЛТГЭХ УДИРДАМЖ

https://mof.gov.mn/article/entry/news-07-10

**Улаанбаатар хот**

**2020 оны 7 дугаар сарын 5**

# Агуулга

1. Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого, зарчим ... 3

2. Төсвийн хязгаар ... 3

3. Монгол Улсын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар ... 7

3.1. Өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйлс: ... 7

3.2. Төсвийн орлого ... 8

3.3. Төсвийн урсгал зардлын санал бэлтгэх ... 9

3.4. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал бэлтгэх ... 9

3.5. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний санал бэлтгэх ... 10

3.6. Төсвийн санал хүлээн авч хянах ... 11

3.7. Орон нутгийн 2021 оны төсвийн суурь орлого, суурь зарлагын саналыг хянах 12

3.8. Төсвийн урсгал зардал, эргэж төлөгдөх зээлийн саналыг төсвийн төлөвлөлтийн FISCAL программд оруулах ... 12

3.9. Төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС) ... 12

3.10. Үр дүнд суурилсан төсөвлөлт ... 15

3.11. Төсвийн ангилал ... 16

3.12. Төсвийн саналын маягт бөглөх заавар: ... 16

4. Хавсралт ... 19

4.1. Төсвийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарах ажилтны мэдээлэл ... 19

4.2. Төрийн албан хаагчийн орон тооны мэдээлэл ... 20

## 1. Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого, зарчим

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас 2020 онд эдийн засгийн суурь тооцоолол буурах хүлээлттэй байгаа бол 2021 онд халдварын нөлөө саарснаар эдийн засгийн салбарууд эргэн сэргэж, цаашид дунд хугацааны өсөлтийн түвшинд хүрч, тогтворжих төлөвтэй байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар 2021 онд 500 сая ам.долларын Мазаалай бонд, 2022 онд 1.0 тэрбум ам.долларын Чингис бонд, 2023 онд 800 сая ам.долларын Гэрэгэ бондын төлбөрүүдийг төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүй байх өрийн менежмент хэрэгжүүлэн төлнө. Үүнтэй уялдуулан ирэх жилүүдэд төсвийн алдагдлыг үе шаттай бууруулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан түвшинд буюу 2023 оноос ДНБ-ий -2.0 хувьд хүргэхээр ажиллаж байна. Ирэх онуудад баримтлах гол бодлогын арга хэмжээнүүдийг дурдвал:

- Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас үүссэн сөрөг үр дагаврыг арилгах, эдийн засгийг идэвхжүүлэх, тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлнэ
- Төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаарт багтаан 2021 онд ДНБ-ий -3.6 хувь, 2022 онд ДНБ-ий -2.8 хувь, 2023 онд -2.0 хувь байх бодлого баримтална
- Засгийн газрын зүгээс 2021-2024 онуудад төлөгдөх нийт 2.9 тэрбум ам.долларын өндөр хүүтэй гадаад үнэт цаасны төлбөрийн төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүй байх өрийн менежментийг хэрэгжүүлнэ
- Гааль, татварын шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, бизнесийн орчныг сайжруулна
- Төсвийн зарлагын шинэчлэлийг үргэлжлүүлж, төсвийн урсгал зардлыг хэмнэх, оновчтой үр ашигтай төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх, тэтгэвэр, тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлнэ
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байхаар төлөвлөнө

## 2. Төсвийн хязгаар

Дэлхий даяар коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийн улмаас улсын болон орон нутгийн төсөвт төвлөрдөг гол нэр төрлийн татварын болон татварын бус орлого төлөвлөснөөс доогуур гүйцэтгэлтэй байна. Иймд төсвийн зарлагын 2021 оны нийт хязгаарыг 9,868.1 тэрбум төгрөг байхаар тооцлоо

**Төсвийн орлого**

Төсвийн орлогын чиглэлээр дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

**Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар баталж, 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхлээд буй татварын багц хуулийн хэрэгжилтийг хангана.** Хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг

сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээл, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж, иргэд, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг бууруулах, татварын суурийг тэлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Татварын албаны бүртгэл, мэдээллийн системийг бэхжүүлж, цахим төлбөрийн систем, хөндлөнгийн мэдээлэл солилцоог сайжруулж, татвар төлөх, тайлагнах, түүнд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах, цаг зардлыг бууруулна;

**Гаалийн шинэчлэл хийж, хилийн боомтын нэвтрүүлэх, хяналт тавих хүчин чадлыг сайжруулна.** Уул уурхайн бүтээгдэхүүн болон импортын барааны чанар, агуулга, тоо хэмжээг шуурхай нарийвчлан тодорхойлж, татварыг бүрэн ногдуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулна. Улмаар гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг түргэн шуурхай, чирэгдэл багатай хийж, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлж, бизнесийн үйл ажиллагааг нь дэмжиж ажиллана.

Улсын Их Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан Газрын төлбөрийн тухай хууль, Газрын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж газрын бүртгэлийн мэдээллийг ил тод болгох, газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг цахимжуулах замаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд газрын төлбөрөө хялбараар төлөх боломжийг бүрдүүлж, газрын төлбөрийн орлогыг бүрэн хураана.

### Төсвийн зарлага

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны урсгал зардлын төлөвлөлтөд дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхээр тооцов. Үүнд:

**Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын эрсдэлийг даван туулахад чиглэсэн төсвийн урсгал зарлагын оновчтой хуваарилалт хийж, тэвчиж болох зардлыг бууруулна.** Халдварт цар тахлын эрсдэл нь эдийн засгийн өсөлтийг саарuулж улмаар энэ нь ард иргэдийн амьжиргаа, аж ахуйн нэгж бизнесийн орлогод нөлөөлөх үр дагаварт хүргэж байна. Үүний хариу үйлдэл болгож Засгийн газраас эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжүүдийг дэмжих чиглэлээр 2020 онд батлагдсан төсвийн хөрөнгийг дахин хуваарилах, тэвчиж болох урсгал зардлыг бууруулах зэрэг зохицуулалтыг хийж байна. Эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн орлогын бүрдэлт болон ойрын хугацаанд цар тахлын тодорхойгүй нөхцөл байдал зэргээс шалтгаалж ирэх 2021 онд хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тооцож жилийн урсгал төсвийн хязгаарыг тогтоосон болно.

**Цалин хөлсний зардлын төлөвлөлт болон гүйцэтгэлийн хяналтыг сайжруулна.** Төрийн байгууллагын нийт орон тоо, цалингийн зардлын төлөвлөлт, зарцуулалтыг нэгдсэн системд оруулж төсвийн үргүй зардлыг бууруулах зорилтын хүрээнд төрийн албаны хүний нөөц, шилжилт хөдөлгөөний нэгдсэн мэдээллийн санд суурилсан төрийн албан хаагчийн цалин хөлсний төлөвлөлт, санхүүжилтийн системд төсвийн байгууллагуудыг хамруулах ажлыг 2020 оны 5 дугаар сараас эхлэн үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2021 онд улсын хэмжээнд бүрэн нэвтрүүлнэ.

**Төсвийн зарлагын удирдлагын шинэчлэлийн хүрээнд тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн, үр дүн-нотолгоонд суурилсан дунд хугацааны төлөвлөлтийг нэвтрүүлнэ.** Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтот үзүүлэлтийг сайжруулахад чиглэсэн төсвийн төлөвлөлтийг жендерийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн хамтаар сонгосон салбарын хөтөлбөрүүдэд туршин нэвтрүүлэлтийг үргэлжлүүлж, хамрах хүрээг өргөтгөнө. Энэ хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн зорилтыг хангахад чиглэсэн төсвийн төлөвлөлтийн шинэ аргачлалыг эрүүл мэнд, байгаль орчны салбарт, жендерийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн салбарт туршин нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

**Орон нутгийн суурь орлого, суурь зарлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны төсвийн хязгаарт туссан орон нутгийн суурь орлого, зарлагыг өмнөх жилүүдийн өсөлт, бууралтыг үндэслэн 2020 оны батлагдсан төсвийг суурь болгон төсвийн хязгаарыг тооцлоо. Урьдчилсан байдлаар аймаг, нийслэлийн суурь орлого, зарлагыг дараах байдлаар тооцоод байна. Үүнд:

**Хүснэгт 1. Орон нутгийн 2021 оны төсвийн төслийг хянахад баримтлах суурь орлого, суурь зарлагын хэмжээ (сая.төгрөг)**

| | | Суурь орлого | Суурь зарлага | |
|---|---|---|---|---|
| | | | Төсвөөс санхүүжих | ОНХС-с санхүүжих |
| | | .1. | .2. | .3. |
| 1. | *Архангай* | 8,228.5 | 20,940.7 | 540.0 |
| 2. | *Баян-Өлгий* | 10,381.4 | 17,259.7 | 358.6 |
| 3. | *Баянхонгор* | 9,628.8 | 28,059.0 | 638.5 |
| 4. | *Булган* | 21,760.7 | 24,670.0 | 534.3 |
| 5. | *Говь-Алтай* | 7,378.6 | 21,990.8 | 479.4 |
| 6. | *Дорноговь* | 27,738.4 | 21,751.6 | 184.5 |
| 7. | *Дорнод* | 19,129.4 | 16,968.5 | 500.0 |
| 8. | *Дундговь* | 6,139.3 | 17,483.6 | 244.5 |
| 9. | *Завхан* | 8,026.7 | 26,871.5 | 308.4 |
| 10. | *Өвөрхангай* | 12,149.9 | 27,995.7 | 482.9 |
| 11. | *Өмнөговь* | 140,174.3 | 47,745.2 | 376.8 |
| 12. | *Сүхбаатар* | 9,175.1 | 19,015.8 | 494.8 |
| 13. | *Сэлэнгэ* | 23,234.4 | 26,939.6 | 482.5 |
| 14. | *Төв* | 20,703.2 | 31,387.6 | 538.7 |
| 15. | *Увс* | 9,130.0 | 33,586.0 | 439.9 |
| 16. | *Ховд* | 11,776.6 | 21,679.8 | 533.1 |
| 17. | *Хөвсгөл* | 12,077.9 | 31,913.2 | 962.4 |
| 18. | *Хэнтий* | 12,783.1 | 23,864.4 | 558.4 |
| 19. | *Дархан-Уул* | 24,202.3 | 16,241.2 | 1,025.1 |
| 20. | *Улаанбаатар* | 1,022,740.9 | 316,207.9 | 227.9 |
| 21. | *Орхон* | 66,227.1 | 18,256.8 | 301.1 |
| 22. | *Говь-Сүмбэр* | 5,133.5 | 7,112.3 | 60.3 |
| | **Нийт** | **1,487,920.0** | **817,940.9** | **10,272.3** |

**Орон нутгийн хөгжлийн сан**

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2021 онд аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд дараах эх үүсвэрээс тус тус тооцон орлогын шилжүүлэг олгоно. Үүнд:

1. Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ- 5 хувь
2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого-5 хувь
3. Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого-30 хувь

4. Тогтвортой амьжиргаа төслөөс олгох гүйцэтгэлд суурилсан урамшуулал-шалгуур үзүүлэлт хангасан сумдын 2019 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн 25 хувь хүртэл хэмжээнд урамшуулал тооцно.

5. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого-100 хувь.

6. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого-50 хувь.

7. Ашигт малтмалын тухай хуулийн $47^3$ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 60 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн “Журам батлах тухай” 228 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу хуваарилна.

# 3. Монгол Улсын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар

## 3.1. Өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйлс:

1) Төсвийн төлөвлөлтийн системийн сайжруулалт хийгдэж байгаатай холбогдуулан орон нутгийн төсвийн саналыг энэ жилээс эхлэн BPIS системд бус харин FISCAL программд оруулахаар болсонтой холбогдуулан зааварчилга шинээр нэмэгдсэн

2) “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай” Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан орон нутаг дахь улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудад өгөх зааварчилга, түүнчлэн нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон нийслэлийн төсвийн байгууллагуудад өгөх зааварчилга шинээр нэмэгдсэн.

3) “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны салбарын холбогдох хөтөлбөрүүдэд хуваарилах төсвийн саналыг шинэ аргачлалаар хүлээн авахтай холбогдуулан удирдамжийн хавсралт (**05.Нотолгоо ба үр дүнд суурилсан төсвийн санал бэлтгэх аргачлал.docx**)-ыг шинэчилсэн. Мөн **02.Төсвийн санал бэлтгэх маягт 2021.xls** файлд **ТМ-01(ТЗХ)** маягтыг шинээр нэмсэн.

4) Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний саналыг https://pims.publicinvestment.gov.mn хаягаар хүлээж авч эхлэсэнтэй холбогдуулан **01.Төсвийн саналын маягт-2020.xlsx** хавсралтаас **НМ-08** маягтыг хассан.

5) Төрийн албан хаагчийг өндөр насны тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн тэтгэмж олгох зардлын хэмжээг тооцоход ашигладаг **НМ-07а.Тэтгэвэрт гарах албан хаагчийн мэдээлэл** маягтын бүтэц шинэчлэгдсэн. Үүнтэй холбогдуулан мөн шинээр **НМ-07б.Тэтгэвэрт гарах албан хаагчийн үндсэн цалингийн тооцоолол** болон **НМ-07в.Тэтгэвэрт гарах албан хаагчийн төрд ажилласан байдлын мэдээлэл** маягтууд шинээр нэмэгдсэн.

6) Монгол Улсад “Жендерийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт”-ийг ерөнхий ба сургуулийн өмнөх боловсрол, мэргэжлийн боловсрол, залуучуудын хөдөлмөр эрхлэлт зэрэг хөтөлбөрүүдэд 2021 оноос эхлэн туршин нэвтрүүлэхтэй холбогдуулан БСШУСЯ, ХНХЯ-д хүргүүлэх товч танилцуулга нэмэгдсэн.

## 3.2. Төсвийн орлого

Орон нутгийн 2021 оны төсвийн орлогын төсөөллийг боловсруулахад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн болон татварын хууль тогтоомжийг мөрдөж, орлогын боломжит эх үүсвэрүүдийг дайчлах, бааз суурийг өргөжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд ач холбогдол өгч ажиллах бөгөөд дараах зарчмыг баримтална:

3.1.1. Засгийн газар баталсан суурь орлогын хэмжээг бууруулахгүй байх;

3.1.2. Эдийн засгийн суурь үзүүлэлт болон холбогдох мэдээлэл, тооцоо, судалгаанд үндэслэн төсвийн орлогын төсөөллийг боловсруулах;

3.1.3. Шинээр батлагдсан хууль тогтоомж, төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөө үзүүлэх үр дагавар бүхий шийдвэрийн нөлөөллийг тооцож, холбогдох мэдээлэл материалыг хавсаргаж ирүүлэх (Иргэдийн хурлын тогтоол г.м);

3.1.4. Хувь хүний орлогын албан татварын орлогыг төсөөллийг боловсруулахад Нийгмийн даатгалын байгууллагад байгаа цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвар төлөгч иргэдийн мэдээллийг татварын мэдээллийн баазтай тулгаж, хөдөлмөр эрхлэгчдийн тоо, цалингийн сан, ажилласан хугацаа зэргийн гүйцэтгэлийг 2020 оны хагас жилийн болон өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар гаргаж төсөөллийг боловсруулахад ашиглах;

3.1.5. Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын орлогыг тооцоход шаардагдах мэдээллүүдийг холбогдох банк, санхүүгийн байгууллагаар гаргуулж, эдгээр мэдээлэлд үндэслэн орлогын тооцооллыг хийх;

3.1.6. Хөрөнгийн татварын орлогын төсөөллийг хийхэд хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийн мэдээллийг ашиглах;

3.1.7. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг эдийн засгийн ангиллын дагуу тус бүрээр тооцож, тооцоо судалгааг холбогдох баримтын хамт ирүүлэх;

3.1.8. Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн олборлолт, борлуулалтын төсөөллийн талаарх мэдээллийг бэлтгэх;

3.1.9. Төрийн өмчит компаниас төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээний төсөөллийг аж ахуйн нэгж бүрээр хийх;

3.1.10. Орон нутгийн төсвийн орлогын тооцооллыг энэхүү удирдамжид хавсаргасан маягтын дагуу хийж, шаардлагатай мэдээллийг ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлээгүй тохиолдолд орлогын төсөөллийг Сангийн яаманд байгаа мэдээлэлд үндэслэн боловсруулах болно гэдгийг анхаарах.

3.1.11. Орон нутгаас төсвийн орлогын төлөвлөлттэй холбоотойгоор ирүүлсэн тооцоо, судалгаа, мэдээллийг тодруулах зорилгоор Сангийн Яамнаас тухайн орон нутгийн төсвийн мэргэжилтэнтэй утсаар шууд холбогдох тул орлогын төлөвлөлтийг хянах хугацаанд бэлэн байдлыг хангаж ажиллах.

3.1.12. Орон нутгийн төсвийн орлогын тооцооллыг энэхүү удирдамжид хавсаргасан (**03.ОН төсвийн орлогын тооцоолол.xlsx)**

## 3.3. Төсвийн урсгал зардлын санал бэлтгэх

1. Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийг **02.Төсвийн саналын маягт-2021.xlsx**-ын дагуу бэлтгэх (**Бүх ТЕЗ нар** *нарийвчилсан зааварчилгааг энэхүү удирдамжийн 4.1 дэх хэсгээс харах )*

2. Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны салбарын холбогдох хөтөлбөрүүдэд хуваарилах төсвийн саналыг шинэ аргачлалаар хүлээн авахтай холбогдуулан (**05.Нотолгоо ба үр дүнд суурилсан төсвийн санал бэлтгэх аргачлал.docx**)-маягтын дагуу бэлтгэж ирүүлэх **(ЭМЯ, БСШУСЯ, БОАЖЯ** *нарийвчилсан зааварчилгааг энэхүү удирдамжийн 3.10 дахь хэсгээс харах* **)**;

## 3.4. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал бэлтгэх

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

1.1. Төсвийн тухай хуулийн 6 болон 31 дүгээр зүйл, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журам, 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ын дагуу төлөвлөх;

1.2. Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын дагуу, улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр дараах байдлаар төслүүдийг төлөвлөх. Үүнд:
   - хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн аргачлалын дагуу Сангийн яамнаас цахим системээр хүргүүлсэн эхний шатны үнэлгээний шаардлага хангасан шинээр хэрэгжүүлэх төслүүдэд сонгох шатны үнэлгээг хийх;
   - он дамжин хэрэгжих төслүүдэд дахин үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ хийх;

1.3. Салбарын болон төслүүдийн танилцуулга, мэдээлэл, судалгааг ирүүлэх;

1.4. Төсвийн тухай хуулийн 14.2 дахь заалтын дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

1.5. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтын дагуу шинээр эхлэх төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс 2020 онд санхүүжих дүн нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байх;

1.6. Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу төсөл, арга хэмжээг төлөвлөх;

1.7. Барилгын тухай хуулийн 15.2, 13.2 дахь, Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтын дагуу 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь экспертизээр батлагдсан зураг төсвийг цахим системд оруулсан байх;

1.8. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд багц дүнгээр батлагддаг төслүүдийн задаргаа, холбогдох материалыг ирүүлэх;
1.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн улсын төсвийн урсгал зардалд үзүүлэх нөлөөллийн тооцоо, төсөл хэрэгжсэнээр шинээр бий болох ажлын байрны судалгаа, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын мэдээллийг 295 дугаар тушаалын дагуу хийж, цахим системд оруулсан байх;
1.10. Төсвийн тухай хуулийн 31.4 дэх заалтын дагуу нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй гэж тооцоолсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсвэл санхүүжилтийг бууруулах санал, тооцоог ирүүлэх;
1.11. Улсын болон салбарын бодлогын хүрээнд ач холбогдлоор нь эрэмбэлсэн байх;
1.12. Төсөл, арга хэмжээний нэр томьёо, байршил, хүчин чадал, хэмжих нэгж жигд, мөнгөн илэрхийллийг саяар цахим системд оруулсан байх;

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг 2019 оны 8 дугаар сарын 15-ны дотор албан тоотоор болон цахим системээр хүлээн авна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчид хөрөнгө оруулалтын төслийн саналаа бэлтгэхдээ цахим системд заасан үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд дээрхи шаардлагуудыг хангахгүй, холбогдох материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

### 3.5. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний санал бэлтгэх

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2021 оны гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн саналаа боловсруулахдаа Засгийн газраас баталсан зарлагын хязгаар болон дунд хугацаанд зээл, тусламжид баримталж байгаа бодлого, чиглэлийг удирдлага болгон, **НМ-09** маягтад заасны дагуу саналыг бэлтгэх бөгөөд төсөл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд,

1. гадаадын зээл, тусламжаар 2021 онд хэрэгжих төслүүдийг шилжих, дуусах болон шинэ төсөл тус бүрээр гарган, танилцуулгын хамт ирүүлэх;
2. зардлыг урсгал, хөрөнгийн болон эргэн төлөгдөх нөхцөлтэй зардлын ангилалд зөв тусгахад анхаарч, эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллын дагуу төсвийн төслийг бэлтгэсэн байх;
3. санхүүжих эх үүсвэр хэсэгт эх үүсвэрийг тодорхой тусгах, ингэхдээ гадаадын зээл, тусламж болон улсын төсвийн эх үүсвэрийн санхүүжилтийг тодорхой болгох;
4. зээл, тусламжийн төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлын саналыг 1-3-д заасны дагуу тусад нь тооцож гаргах;

5. төслийн төлөвлөгөөний саналыг гэрээний үндсэн валют болон төгрөг гэсэн 2 дүнгээр боловсруулах ба үндсэн валютыг төгрөгт хөрвүүлсэн өдрийн ханшны мэдээллийг оруулсан байх;
6. гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн монголын тал хариуцах хөрөнгийн болон урсгал зардлын саналыг 1-3-д заасан мэдээллээр гаргах ба танилцуулга, талуудын байгуулсан гэрээний холбогдох заалтын мэдээллийг хавсаргах;
7. эргэн төлөгдөх нөхцөлтэй ангилалд тусгагдсан зээлийн төслийн гэрээний хуулбарыг хамт ирүүлэх;
8. Түүнчлэн гадаадын зээл, тусламжаар 2020 онд хэрэгжиж буй төслүүдийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн тооцоог хамт ирүүлнэ. Ингэхдээ урсгал, хөрөнгө болон эргэн төлөгдөх зардлыг нийт дүнгээр гаргаж, төслийн үндсэн үйл ажиллагааны данс болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн данс тус бүрээр салган хүлээгдэж буй гүйцэтгэлийн тооцсон байна. Мөн төслийн хэрэгжилтийн явц байдал, 2020 оны хэрэгжилтэд учирсан асуудал, хүрсэн үр дүнгийн танилцуулгыг хамт ирүүлнэ.

## 3.6. Төсвийн санал хүлээн авч хянах

Улсын төсөв, НДС-ийн төсөв, ЭМДС-ийн төсөв болон орон нутгийн төсөвт хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналыг дор дурдсан хугацаанд хянаж Засгийн газар болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэнэ. :

**Хүснэгт 2. Төсвийн төсөл бэлтгэх процесс**

| **Хяналт болон төлөвлөлтийн процесс** | **Эхлэх болон дуусах хугацаа** |
|---|---|
| Аймаг, нийслэлийн 2021 оны төсвийн суурь орлого, суурь зарлагын саналыг цахимаар хянах | VIII/03- VIII/17 |
| Улсын төсөв, НДС-ийн төсөв, ЭМДС-ийн төсвийн саналыг хүлээн авч хянах | VIII/17- IX/01 |
| Жилийн төсвийн төсөлд инфляцын болон бусад бодлогын тохируулга хийх | IX/01- IX/10 |
| Монгол Улсын 2020 оны төсвийн төсөл, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн төслийг тус тус холбогдох бусад материалын хамт Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэх | IX/10- IX/15 |
| ТЕЗ нартай 2020 оны төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг хийж холбогдох тохируулгыг хийн, УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлтгэх | IX/15- IX/30 |

Төсвийн Ерөнхийлөн захирагчид төсвийн төслийн саналаа бэлтгэхдээ маягтад заасан үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд дээрх шаардлагуудыг хангахгүй, холбогдох

материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

### 3.7. Орон нутгийн 2021 оны төсвийн суурь орлого, суурь зарлагын саналыг хянах

Коронавирусын халдварт (COVID-19) цар тахлын эрсдэлийг бууруулахтай холбогдуулан 1/ хүмүүс нэг дор олноор цуглуулахгүй байх 2/ төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардал, тухайлбал дотоод албан томилолт, тээвэр шатахууны зардлын санхүүжилтийг бууруулсан зэргийг үндэслэн аймгийн Санхүү төрийн сангийн дарга болон төсвийн суурь орлого, суурь зарлага хариуцсан мэргэжилтнийг Сангийн яаманд ирүүлэхгүйгээр FISCAL программ ашиглан орон нутгийн төсвийн саналыг хянах болсныг анхаарна уу.

### 3.8. Төсвийн урсгал зардал, эргэж төлөгдөх зээлийн саналыг төсвийн төлөвлөлтийн FISCAL программд оруулах

Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар FISCAL программын шинэчилсэн баазыг Сангийн яамны ТБТГ-ын зөвлөх Ш.Оюунбаатараас цахим шуудангаар авах ба бэлтгэсэн саналаа удирдамжийн 3.6-д заасан хуваарьт заасан хугацааны дотор буцаан илгээнэ. Харилцах хаяг: oyunbaatar@mof.gov.mn, холбогдох утасны дугаар **51-265753**.

### 3.9. Төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 163 дугаар тогтоолоор төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлж, төрийн албан хаагчийн орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн албаны хүний нөөцийн мэдээлэлд суурилсан Төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)-ийг 2020 оны 5 дугаар сараас бүх шатны төсвийн байгууллагад үе шаттайгаар нэвтрүүлэхээр шийдвэрлээд байна.

ТАЦНС нэвтрүүлэх нь цалин хөлсний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт болон хяналтыг бүрэн автоматжуулах буюу төсвийн байгууллагын нягтлан бодогчдод төрийн албан хаагчдын хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл цалин хөлс, суутгалын тооцооллыг үнэн зөв бодитой тооцоход нь дэмжлэг үзүүлэх, холбогдох тайлан мэдээг нийгмийн даатгалын болон татварын байгууллагад автоматаар илгээх, хувь хүний цалин хөлсний төлбөрийг банк хоорондын системээр дамжуулан албан хаагчийн цалингийн дансанд шууд шилжүүлэх зэрэг давуу талуудтай юм .

Сангийн яам систем нэвтрүүлэлтийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын ажилтнуудыг сургагч багшаар бэлтгэх онлайн сургалтыг үе шаттайгаар явуулж дуусаад байна. Эхний шатанд 21 аймаг дахь улсын болон орон нутгийн төсвийн нийт 3268 байгууллагаас 1423 байгууллагын үндсэн болон гэрээт ажилтнуудын албан тушаалын болон цалин хөлсний мэдээллийг Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд шинэчлэн оруулсны үндсэн

дээр 5 дугаар сарын цалин хөлсийг ТАНЦС-д тооцоолж бодит цалингийн төсөвтэй нь тулгалт хийж дуусгаад байна.

**Хүснэгт. 21 аймаг дахь улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын Төрийн албаны цалингийн системд нэвтэрсэн байдал**

| № | Аймаг | Системд нэвтрэх байгууллагын тоо | Системд нэвтэрсэн байгууллагын тоо | Нэвтрүүлэл-тийн хувь | Цалин бодолт хийсэн байгууллага | Цалин бодолтын хувь |
|---|---|---|---|---|---|---|
| *А* | *Б* | *1* | *2* | *3=2/1* | *4* | *5=4/1* |
| 1 | Архангай | 172 | 129 | 75% | 29 | 16.9% |
| 2 | Баян-Өлгий | 167 | 158 | 95% | 47 | 28.1% |
| 3 | Баянхонгор | 180 | 173 | 96% | 65 | 36.1% |
| 4 | Булган | 148 | 143 | 97% | 112 | 75.7% |
| 5 | Говь-Алтай | 172 | 156 | 91% | 11 | 6.4% |
| 6 | Дорноговь | 149 | 149 | 100% | 141 | 94.6% |
| 7 | Дорнод | 142 | 140 | 99% | 121 | 85.2% |
| 8 | Дундговь | 132 | 125 | 95% | 71 | 53.8% |
| 9 | Завхан | 197 | 193 | 98% | 114 | 57.9% |
| 10 | Өвөрхангай | 187 | 185 | 99% | 1 | 0.5% |
| 11 | Өмнөговь | 149 | 128 | 86% | 27 | 18.1% |
| 12 | Сүхбаатар | 122 | 119 | 98% | 68 | 55.7% |
| 13 | Сэлэнгэ | 202 | 198 | 98% | 75 | 37.1% |
| 14 | Төв | 201 | 194 | 97% | 35 | 17.4% |
| 15 | Увс | 171 | 154 | 90% | 39 | 22.8% |
| 16 | Ховд | 164 | 162 | 99% | 116 | 70.7% |
| 17 | Хөвсгөл | 203 | 193 | 95% | 74 | 36.5% |
| 18 | Хэнтий | 177 | 177 | 100% | 96 | 54.2% |
| 19 | Дархан-Уул | 92 | 92 | 100% | 87 | 94.6% |
| 20 | Орхон | 92 | 86 | 93% | 60 | 65.2% |
| 21 | Говь-Сүмбэр | 49 | 48 | 98% | 34 | 69.4% |
| **#** | **Бүгд** | **3,268** | **3,102** | **95%** | **1,423** | **43.5%** |

Ирэх 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс ТАЦНС-д бүх шатны төсвийн байгууллагын бүрэн хамруулахаар төлөвлөж байгаа тул бүх шатны ТЕЗ болон түүний харьяа байгууллагууд дараахь арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

**А. 21 аймаг дахь улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд:**

1. ТАЦНС-д нэвтрэх эрх аваагүй байгууллагууд нэн яаралтай нэвтрэх эрхээ авч ХНУС-д зохих мэдээллийг шинэчлэн оруулж цалингийн тооцооллыг хийж шалгах;

2. ХНУС-д байгаа албан хаагчийн албан тушаалын ангилал, шатлал, зэрэг дэв болон үндсэн цалин, нэмэгдэл цалин хөлсний мэдээлэлд өөрчлөлт орох, албан хаагч нэмэгдэх, хасагдах, шилжих зэрэг өөрчлөлтийг тухай бүр системд нэн даруй оруулж байх;

3. 2020 оны сүүлийн 6 сарын цалин хөлсний тооцооллыг сар бүр ТАЦНС-д хийж бодит цалингийн цэстэй тулгалт хийж аливаа зөрүү, алдааг тухай бүр илрүүлж засах;

4. Орон тоог бодитой болгох зорилгоор 2021 оны төсвийн санал бэлтгэхдээ тухайн байгууллагын зардлын эдийн засгийн зүйлийн **210801-Бусдаар гүйцэтгүүлэх бусад ажил үйлчилгээ** ангиллаас цалин олгож НДШ төлж байгаа гэрээт ажилтнуудын зардлыг **2101-Цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулал** бүлгийн харгалзах ангилалд шилжүүлж, орон тоог ТАЦНС болон FISCAL программын гэрээт ажилтан ангилалд тус тус оруулах. Орон тооны тулгалтыг Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтэс болон ТАЦНС нэвтрүүлэлтийн баг тухай бүр хийх учир мэдээллийг үнэн зөв бодитой оруулах шаардлагатайг анхаарна уу.

**Б. Нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд:**

1. Дараахь хуваарийн дагуу Төрийн албаны зөвлөлийн ХНУС дэх албан хаагчдын мэдээллийг шинэчлэх болон ТАЦНС-ийн сургалт-семинарт хүний нөөцийн болон санхүүгийн асуудал хариуцсан мэргэжилтнийг бүрэн оролцуулах:

**Хүснэгт. Улаанбаатар хот дахь улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын мэдээллийг ХНУС-д шинэчилж ТАЦНС-д холболт хийх хуваарь**[1]

| ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ | 2020 оны сүүлийн хагас | | | | |
|---|---|---|---|---|---|
| | VII | VIII | IX | X | XI |
| **НИЙТ БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **138** | **230** | **144** | **140** | **140** |
| **Улсын төсөв** | **127** | - | - | **14** | **135** |
